



“РЕМИКОН” ХХК-ийн  
хувьцаа эзэмшигчдэд

## “ШОНХОР ҮНЭЛГЭЭ АУДИТ” ХХК

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
6 дугаар хороо, Метро бизнес оффис,  
6 дугаар давхар 603 тоот

Утас: 70150001, 80110088  
Цахим хаяг: [www.shonkhor.mn](http://www.shonkhor.mn)  
И-мэйл: shonkhor.mn@gmail.com

2024. 01. 30 № 24/11

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

Аудитын гэрээт ажлын захидал

Таны энэ өдрийн амар амгаланг айлтгая

“РЕМИКОН” ХХК-ийн 2023.12.31-нээрх тасалбар болгосон санхүүгийн зэрэгцүүлсэн мэдээлэлд аудит хийлгэх тухай хүсэлтийг хүлээн авч байгаагаа илэрхийлэн, дор дурдсан зарчмын зүйлүүдийг энэхүү захидаар Та бүхний сонорт хүргэхийг хүсч байна.

Энэхүү гэрээт ажил нь юуны өмнө танай компанийн 2023.12.31-нээрх тасалбар болгосон санхүүгийн тайланг Монгол улсын хууль, Санхүүгийн тайлангийн олон улсын стандартын дагуу шалгаж, үнэлэх зорилготой. Бид гүйцэтгэсэн ажлынхаа үр дүнд үндэслэн танай санхүүгийн тайлангийн талаар аудиторын тайлан, дүгнэлт гаргах буюу мэргэжлийн саналаа илэрхийлэх үүрэгтэй.

Санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн тайлагналын болон Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартуудын зарчмуудад нийцүүлэн бэлтгэж танилцуулах нь танай байгууллагын удирдлагын хүлээх үүрэг хариуцлага болно. Энэхүү үүрэг хариуцлагад санхүүгийн тайлангуудыг үнэн бодитойгоор бэлтгэх, дотоод хяналт, нягтлан бодох бүртгэлийн бодлогуудыг сонгож хэрэглэх, эдгээрийн үр дүнг нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайланда шударгаар толилуулах зэрэг үүргүүд багтана.

Өмч хөрөнгийн аюулгүй байдлыг хангаж, үр нөлөө бүхий нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтыг хууль стандартын дагуу тогтмол үр дүнтэй ажиллуулах нь удирдлагын хууль ёсны үүрэг байдаг.

Санхүүгийн тайлангийн аудитыг Нягтлан Бодогчдын Олон Улсын Холбоо /IFAC/-ны Аудит Баталгаажуулалтын Олон Улсын Стандартын Зөвлөлөөс батлан гаргасан Аудитын Олон Улсын Стандарт /АОУС/-ын дагуу гүйцэтгэнэ. Энэ стандарт нь санхүүгийн тайлангууд материаллаг алдаа ба буруу тайлагналаас ангид илэрхийлэгдсэн эсэх талаар дунд түвшний баталгаа гаргах чиглэл удирдамж болдог. Аудитыг байгууллагын ажилтнуудаас асуулга тавьж харилцан ярилцах, санхүүгийн тайлан дахь тоон мэдээллүүдэд тулгуурласан шинжилгээ судалгаа харьцуулалт, тулган баталгаажуулалт хийх, давтан гүйцэтгэх, хөөн шалгах болон аудитын сорил горимуудаар хэрэгжүүлдэг.

Бид гэрээт ажлаа Аудитын тухай хуулийн зарчимд нийцүүлэн урьдчилан боловсруулсан төлөвлөгөөний дагуу гүйцэтгэнэ. Нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан бэлтгэхэд баримталсан зарчим сонгож хэрэглэсэн аргыг бүхэлд нь үнэлнэ. Удирдлагын шийдвэр үлэмж хэмжээний дүн бүхий тооцоолол онцлог үйл явдлуудын бүртгэл ба үйл явдлуудыг тусгайлан авч үзнэ.

Санхүүгийн тайлан ба нэмэлт тодруулгад тусгагдсан мэдээллийн талаар нотлох зүйл олж авахын тулд түүврийн болон бусад сорил горимуудыг ашиглана. Аудитын ажлын үр дүнд танай байгууллагын 2023.12.31-нээрх үлдэгдлийн тэнцэл, орлого, үр дүн болон мөнгөн гүйлгээ нь нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлангийн талаарх Монгол улсын хууль тогтоомж, Сангийн яамнаас баталж мөрдүүлсэн заавар аргачлалын дагуу үнэн бөгөөд шударгаар илэрхийлсэн эсэхийг тодруулан тайлagnah болно. Та бүхнээс бэлтгэж толилуулсан санхүүгийн тайланд хийсэн аудитын ажлын тайлангийн бодит байдал нь бидний хүлээх хариуцлага болно.

Аудитын ажлын онцлог, үйлчлүүлэгчийн бүртгэл, хяналтын онцлог, сул тал сөрөг нөлөөтэй бусад хүчин зүйлүүдээс шалтгаалан, залилан ба материаллаг алдаа бүхий тайлagnalыг илрүүлэх, илрүүлэхгүй байх тохиолдол гарахыг бид угүйсгэхгүй. Зайлсхийх боломжгүй ийм эрсдэлүүд аудитын ажлын практикт түгээмэл байдаг. Бид ийм алдаа гаргахгүй байхыг эрхэмлэн, тодруулах шаардлагатай болон материаллаг алдаатай мэдээлэл, бусад зүй бус илрүүлэлтийн хувьд холбогдох тайлбар тодруулгыг та бүхнээс тухай бүрд нь авна.

Санхүүгийн тайланд хийх аудитын гэрээт ажлын талаар Талуудын бусад үүрэг хариуцлага, ажлын хугацаа, үйлчилгээний хөлс болон бусад асуудлыг аудитын ажлын гэрээгээр зохицуулна.

Танай байгууллагын 2023.12.31-нээрх тасалбар оны жилийн санхүүгийн зэрэгцүүлсэн мэдээллийн аудитын гэрээт ажлын талаар дээр дурдсан зарчмын зүйлүүд нь энэ ажлын тухай таны ойлголттой нийцэж байвал энэхүү захидлын илүү нэг хувьд гарын үсгээ зурж бидэнд ирүүлнэ үү.

### Та бүхэнд амжилт хүсье. Баярлалаа

ХҮНДЭТГЭСЭН:

“Шонхор үнэлгээ Аудит” ХХК-ийн

Захирал

ХҮЛЭЭН АВСАН:

“РЕМИКОН” ХХК -ийн

Гүйцэтгэх захирал



Д.Шийрэв

Э.Мөнхсайхан